

СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН
2018 ОНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТАНИЛЦУУЛГА



АРВАЙХЭЭР
2019 ОН

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН
2018 ОНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТАНИЛЦУУЛГА**

Танилцуулгыг хянасан Статистикийн хэлтсийн дарга О.Түмэнжаргал

Танилцуулгыг нэгтгэж, боловсруулсан:

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Х. Мөнхцэцэг

Харилцах хаяг: Өвөрхангай аймаг, Арвайхээр сум

Нутгийн удирдлагын ордон, 403 тоот, утас: 70323442

вэб хаяг: <http://uvurkhangai.nso.mn>

АГУУЛГА

Оршил.....	10
I. Аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь.....	11
II. Мал аж ахуй.....	12
II.1 Малын бүтээгдэхүүний үйлдвэрлэлт.....	12
II.2 Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн 2017 оны тооллогын дүн....	14
II.3 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж.....	33
II.4 Тэжээвэр амьтад.....	35
III. Газар тариалан.....	36
Дүгнэлт.....	38
Хавсралтууд.....	39

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт.....	12
Хүснэгт 2. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр.....	13
Хүснэгт 3. Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн.....	13
Хүснэгт 4. Өрх, малчдын тоо, насны бүтэц.....	14
Хүснэгт 5. Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд.....	15
Хүснэгт 6. Малын тоо, төрлөөр.....	17
Хүснэгт 7. Зудны дараах жилийн малын тооны өсөлт, төрлөөр.....	17
Хүснэгт 8. Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд.....	18
Хүснэгт 9. 2001 оноос хойшхи жилүүдийн малын тооны өсөлт, бууралт.....	19
Хүснэгт 10. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь.....	19
Хүснэгт 11. Хувийн малтай өрх, малын тоо.....	21
Хүснэгт 12. Малтай өрхийн малын бүлэглэлт.....	22
Хүснэгт 13. Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр.....	23
Хүснэгт 14. Хээлтэгч малын тоо.....	23
Хүснэгт 15. Төл бойжилт.....	24
Хүснэгт 16. Бойжуулсан төл.....	25
Хүснэгт 17. 100 эхээс бойжуулсан төл.....	26
Хүснэгт 18. Том малын зүй бусын хорогдол.....	26
Хүснэгт 19. Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь.....	27
Хүснэгт 20. Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо.....	27
Хүснэгт 21. Хээл хаяж, сувайрсан эх малын тоо.....	28
Хүснэгт 22. Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь.....	28
Хүснэгт 23. Хээлтүүлэгч малын тоо.....	29
Хүснэгт 24. Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо.....	29
Хүснэгт 25. Малын хэрэглээний зарлага.....	30
Хүснэгт 26. Зах зээлд худалдаж борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо.....	31
Хүснэгт 27. 2018 оны сүргийн бүтэц.....	31
Хүснэгт 28. Сүргийн бүтэц хувиар.....	32
Хүснэгт 29. Бэлчээрийн хүрэлцээ хангамж.....	33
Хүснэгт 30. Бэлчээрийн тэжээл, нэр төрлөөр.....	34
Хүснэгт 31. Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж.....	35

Хүснэгт 32. Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөн үржүүлдэг өрхийн тоо.....	36
Хүснэгт 33. Тариалсан талбай, га-аар.....	37
Хүснэгт 34. Хураасан ургац, тн-оор.....	37

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ДНБ-нд ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь.....	11
Зураг 2. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт бууралт.....	12
Зураг 3. Малчдын тоо, насны бүлгээр.....	15
Зураг 4. Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлтүүд.....	16
Зураг 5. Малын тоо, мянган толгойгоор.....	18
Зураг 6. Нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувь.....	20
Зураг 7. Малын тоогоор тэргүүлсэн сумдууд.....	21
Зураг 8. Хээлтэгч малын тооны өсөлт бууралт.....	24
Зураг 9. Бойжуулсан төлийн тоо.....	25
Зураг 10. 100 эхээс бойжуулсан төлийн тоо.....	25
Зураг 11. Том малын зүй бусын хорогдол.....	26
Зураг 12. Хээл хаялт, сувайралт.....	28
Зураг 13. Малын хэрэглээний зарлага.....	30
Зураг 14. Сүргийн бүтэц, хувиар.....	32
Зураг 15. 100 га хадпан бэлчээрийн талбайд ногдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо.....	33
Зураг 16. Бэлтгэсэн хадлан, тн-оор.....	35

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

1	Малтай өрх, малчин өрхийн тоо.....	41
2	Малчдын тоо, нас хүйсний бүрэлдэхүүн.....	42
3	Малчдын соёл, ахуйн нөхцөл.....	43
4	Малтай өрхийн малын бүлэглэлт.....	45
5	2018 онд малынхаа тоогоор эхний 5 байрт орсон сум, багууд.....	47
6	2018 оны эцэст байгаа нийт малын тоо.....	48
7	2018 оны эцэст байгаа малын тооны өсөлт, бууралт.....	49
8	Нийт малын тооны өсөлт, бууралт.....	51
9	Малтай нэг өрхөд ногдох амины малын тоо	52
10	2018 оны эцэст байгаа амины малын тоо	53

11	2018 оны эцэст байгаа амины малын өсөлт, бууралт.....	54
12	Нийт сүргийн бүтэц.....	55
13	Тэмээн сүргийн бүтэц.....	56
14	Адуун сүргийн бүтэц.....	57
15	Үхэр сүргийн бүтэц.....	58
16	Хонин сүргийн бүтэц.....	59
17	Ямаан сүргийн бүтэц.....	60
18	Хонин толгойд шилжүүлсэн малын тоо.....	61
19	2018 оны эцэст байгаа хээлтэгч мал.....	62
20	Хээлтэгч малын өсөлт, бууралт.....	63
21	Нийт сүрэгт хээлтэгч малын эзлэх хувь.....	65
22	Нийт бойжуулсан төл.....	66
23	100 эхээс бойжуулсан төл.....	68
24	Том малын зүй бусын хорогдол.....	69
25	Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо.....	71
26	Хээл хаясан хээлтэгч.....	73
27	Сувайрсан хээлтэгч.....	75
28	Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	77
29	Малын хэрэглээний зарлага.....	78
30	Зах зээлд худалдаж борлуулсан, аж ахуйн дотоодод хэрэглэсэн мал...80	
31	Сарлагийн тоо.....	81
32	Бэлчээрийн хүрэлцээ хангамж.....	82
33	Бэлтгэсэн өвс.....	83
34	Гар тэжээл	84
35	Гахай, шувууны тоо.....	85
36	Үндсэн эх, өндөглөгчийн тоо.....	86
37	Малжуулалтын тайлан.....	87
38	2018 онд шинээр гаргасан худгийн тайлан.....	88
39	2018 онд засварласан худгийн тайлан.....	89
40	ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ.....	90

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, үхэр - 1 бод.

1 тэмээ - 1.5 бод.

6 хонь - 1 бод.

8 ямаа - 1 бод.

Бог малд хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь

1 адуу - 7 хонь

1 үхэр - 6 хонь

1 хонь - 1 хонь

1 ямаа - 0.9 хонь

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ-4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр-2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал.

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу-Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр-Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 15-20

Азарга - 10-15

Бух - 25-30

Хуц, ухна - 50-67

Малын зүй бусын хорогдолд. өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж.Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

Хадлан өвс -	0.45
Таримал тэжээл -	0.35
Даршны ургамал -	0.25
Гар тэжээл, хужир шүү -	1.0
Үр тарианы хаягдал -	0.9
Лай -	0.4
Сүрэл -	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал.Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна
 1. Бүдүүн тэжээл - өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл - үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно.

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, улс орны боловсруулах үйлдвэрийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагдаж байдаг.

Манай аймгийн эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар гол байр эзэлдэг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн болон газар тариалангийн 2017 оны төлөв байдлыг нэгтгэн тусгав.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, энэ ч утгаараа мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу статистикийн хэлтэс мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг аймгийн хэмжээнд явуулж үр дүнг нэгтгэн гаргадаг.


Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү судалгаа нь мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд суурь мэдээлэл нь болох юм.

I. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2017 оны гүйцэтгэлээр (2018 оны тооцоолол гараагүй болно) манай аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) –ий 47.0 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж, 2018 оны жилийн эцэст нийт хөдөлмөрийн насны хүн амын 40.1 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Зураг 1.

ДНБ-нд ХАА-н салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь



Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбар нь аймгийн ДНБ-ний 60.0-80.0 шахам хувийг эзэлсээр байсан ба 2000 оноос хойшхи хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшигаас үүдэн, мөн үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурах хандлагад шилжиж, улмаар үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, мөн мал аж ахуй болон газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй, баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болдог.

II. МАЛ АЖ АХУЙ

II.1 МАЛ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2017 оны гүйцэтгэлээр (2018 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнийн дүнгийн тооцоо гараагүй байгаа болно) оны үнээр 217.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхтой харьцуулахад оны үнээр 9.3 хувиар өсчээ.

Хүснэгт 1.


Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

	2012	2013	2014	2015	2016	2017	тэрбум төг	
							2017/2016	
							хувь	зөрүү
Тайлант оны үнээр	99.5	163.1	197.7	206.2	199.3	217.9	109.3	18.6

Мал аж ахуйн салбарт 2018 онд 50.7 мянган тн сүү, 18.2 мянган тн мах, 544.0 мянган ширхэг арьс, шир, 1786.9 кг ноос, ноолуур, хөөвөр, хялгас үйлдвэрлэв.

Зураг 2.

ХАА-н салбарын дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, бууралт



Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, биет хэмжээгээр

Бүтээгдэхүүний нэр төрөл	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
						хувь	зөрүү
Сүү, мян.литр	37646.5	45688.2	53351.2	73676.0	50021.8	67.9	-23654.2
ᠡᠢᠶᠠᠶᠢᠡᠡ	408.3	400.3	328.2	600.2	618.0	103.0	17.7
ᠠᠵᠢᠶᠢᠡᠡ	6801.3	8063.4	9584.1	11045.1	5833.5	52.8	-5211.6
ᠰᠢᠶᠢᠶᠢᠡᠡ	24751.5	30153.6	32361.6	23996.9	18346.5	76.5	-5650.4
ᠣᠶᠢᠶᠢᠡᠡ	6685.1	7465.9	5555.4	10390.5	8320.3	80.1	-2070.2
ᠪᠢᠶᠢᠶᠢᠡᠡ	7042.0	7268.1	17422.0	27643.3	16903.6	61.1	-10739.7

2018 онд аймгийн нэг хүнд дунджаар 155.9 кг мах, 428.8 л сүү ногдож байна. /Нийт үйлдвэрлэсэн хэмжээг дотооддоо харьцуулснаар тооцсон ба махны үйлдвэрлэлийг зөвхөн хүнсний хэрэглээнд хэрэглэсэн хэмжээгээр тооцов/.

Нэг хүнд ногдох мал аж ахуйн гол нэрийн бүтээгдэхүүн

	2014	2015	2016	2017	2018
Мах, нядалгааны жингээр*, кг	333.8	445.7	420.1	158.8	155.9
Сүү, л	496.4	579.8	702.8	641.8	428.8

*-махны үйлдвэрлэлийг 2018 онд зөвхөн хүнсний хэрэглээнд хэрэглэсэн хэмжээгээр тооцов.

II.2 МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТАД, ХАШАА ХУДГИЙН 2018 ОНЫ ТООЛЛОГЫН ДҮН

Малтай өрх, малчдын тоо. 2018 онд мал бүхий 19209 өрх тоологдсон ба үүний 83.7 хувь нь буюу 16087 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Малтай өрх аймгийн хэмжээний нийт өрхийн 55.4 хувийг эзэлж байна.

2018 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 28103 малчид ажиллаж байна. Малчин өрхийн ам бүлийн тоо 57747 байгаа ба нэг малчин өрхийн ам бүлийн тоо дунджаар 3.5 байна. Малчдын 43.8 хувь нь буюу 12296 эмэгтэй малчид байна. Малчдыг насны бүлгээр нь авч үзвэл 35.1 хувь нь 34 хүртэлх насны, 54.7 хувь нь 35-аас тэтгэвэрт гарах насны, 10.1 хувь нь тэтгэврийн насны малчид байна.


Өрх, малчдын тоо, насны бүтэц

	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
						хувь	зөрүү
Малтай өрх	17925	17959	18520	18956	19209	101.3	253
Малчин өрх	14115	14658	15407	16087	16307	101.4	220
Малчдын тоо	27580	28446	29993	28265	28103	99.4	-162
Үүнээс:16-34 насны	10720	10857	11087	10162	9866	97.1	-296
35-аас тэтгэвэрт гарах насны	13854	14594	15757	14252	15386	108.0	1134
Тэтгэврийн насны	3006	2995	3149	3851	2851	74.0	-1000
Нийт малчдаас эмэгтэй	13073	13436	14083	12417	12296	99.0	-121
Насны бүтэц %							
Үүнээс:16-34 насны	38.9	38.2	37.0	36.0	35.1	-	-0.9
35-аас тэтгэвэрт гарах насны	50.2	51.3	52.5	50.4	54.7	-	4.3
Тэтгэврийн насны	10.9	10.5	10.5	13.6	10.1	-	-3.5
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	291	308	338	357	335	93.8	-22

2018 онд малтай өрхийн тоо 2017 онтой харьцуулахад 253-аар, малчин өрх 220-иор өсч, малчдын тоо 162-оор буурсан байна.2018 онд 1 малчин өрхөд 335 толгой мал ногдож байгаа нь 2017 оныхоос 22 толгойгоор буурсан байна.

Зураг 3.

Малчдын тоо, насны бүлгээр



Малчдын соёл, ахуйн үзүүлэлт. 2018 оны тооллогоор нийт малчин өрхийн 78.3 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 68.8 хувь нь телевизортой, 18.1 хувь нь радио хүлээн авагчтай, 100.0 хувь гар утастай, 35.2 хувь нь автомашинтай, 54.4 хувь нь мотоцикльтой, 0.2 хувь нь трактортой, 83.2 хувь нь малын хашаатай, 15.3 хувь нь худагтай өрхбайна.


Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд

	Өрхийн тоо						Малчин өрхөд эзлэх хувь					
	2013	2014	2015	2016	2017	2018	2013	2014	2015	2016	2017	2018
Цахилгаантай	11130	12734	12408	12737	12587	12767	82.0	90.2	84.7	82.7	78.2	78.3
Телевизортэй	9439	10848	10710	10685	10780	11217	69.6	76.9	73.1	69.4	67.0	68.8
Автомашинтай	3888	4887	4292	4178	4963	5744	28.7	34.6	29.3	27.1	30.9	35.2
Мотоцикльтой	7043	7737	7636	7365	8169	8869	51.9	54.8	52.1	47.8	50.8	54.4
Трактортай	71	68	54	60	43	30	0.5	0.5	0.4	0.4	0.3	0.2

Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт нарны зайн цахилгаан эх үүсгүүрийн хэрэглээ нэмэгдэж, тэр хэмжээгээр ахуй соёлын үзүүлэлтүүд өссөөр байна.

Зураг 4.

Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлтүүд



Малын тоо. 2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 5461.3 мянга болж, 2017 оныхоос 282.2 мянгаар буюу 4.9 хувиар буурчээ. Энэ онд аймгийн дүнгээр малын тоо нь 4 төрөл дээрээ буурсан, тэмээ өссөн дүнтэй гарсан байна. Малын тооны өсөлт, бууралтыг сумчилж харвал 15 суманд буурсан, 4 суманд өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал Богд, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Төгрөг суманд өссөн дүнтэй байна.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 31451 толгой, адуу 323629 толгой, үхэр 272320 толгой, хонь 2588133 толгой, ямаа 2245813 толгойд хүрч, 2017 оныхоос

тэмээ 2.7 мянгаар өсч, адуу 40.4 мянга, үхэр 25.9 мянга, хонь 75.2 мянга, ямаа 143.4 мянган толгойгоор тус тус буурсан үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 6.

Малын тоо, төрлөөр

мян.толгой

	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
							хувь	зөрүү
Бүгд	3486.0	4111.5	4511.0	5208.6	5743.5	5461.3	95.1	-282.2
Тэмээ	19.7	21.9	23.1	26.3	28.8	31.5	109.4	2.7
Адуу	205.9	246.9	280.2	323.4	364.0	323.6	88.9	-40.4
Үхэр	144.9	183.3	217.6	259.9	298.2	272.3	91.3	-25.9
Хонь	1541.3	1821.1	2021.8	2378.5	2663.3	2588.1	97.2	-75.2
Ямаа	1574.2	1838.3	1968.3	2220.5	2389.2	2245.8	94.0	-143.4

2018 онд 1338.7 мянган толгой төл бойжуулсан нь өмнөх оноос 551.8 мянгаар буюу 29.2 хувиар буурч, том малын зүй бус хорогдол 323.0 мянга буюу 12 дахин өссөн байна. 2018 онд 99686 сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 36.6 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо 2017 оноос 11.6 хувиар буюу 13.1 мянган толгойгоор буурсан байна.

Манай оронд цас их орж, хүйтрэн өвөлжилт хүндэрч, жил дараалан зуд үүрлэсэн жилүүд хамгийн сүүлд 1999-2001 онд мөн 2009-2010 онд шилжих өвөл тохиолдсон байна.


Хүснэгт 7.

Зудны дараах жилийн малын тооны өсөлт, төрлөөр

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1999-2001 оны зудны жилийн дараах жилд						
2002	1665.3	13.3	115.1	75.3	805.9	655.7
2003	1918.8	13.9	123.8	83	881.7	816.4
2003/2002 %	115.2	104.5	107.6	110.2	109.4	124.5
Нийт өсөлтөд 5 төрлийн эзлэх хувь	100.0	0.2	3.4	3.0	29.9	63.4
2009-2010 оны зудны жилийн дараах жилд						
2010	2010.5	14.7	113.8	76.2	896.6	909.2
2011	2425.6	15.9	141.1	90.6	1051.7	1126.3
2011/2010 %	120.6	108.2	123.9	118.9	117.3	123.9
Нийт өсөлтөд 5 төрлийн эзлэх хувь	100.0	0.3	6.6	3.5	37.4	52.3

Зүй бус хорогдсон том малын тоо 1999-2001 онд 1158.5 мянган толгойд хүрч байсан бол 2009-2010 оны зудны жилд 1664.3 мянган толгой мал зүй бусаар хорогдсон. Зудны дараах жилийн малын тооны өсөлтийг хүснэгт 7-оос харвал 2002-2003 онд 15.2 хувиар өсч байсан бол 2010-2011 онд 20.6 хувь өссөн үзүүлэлт гарсан байна. Нийт өсөлтөд 5 төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл 2002 онд нийт өсөлтийн 63.4 хувийг ямаан сүргийн өсөлт хангаж байсан бол 2011 онд 52.3 хувь болж 11.1 пунктээр буурч, хонин сүргийн өсөлт 29.9 хувь байснаа 37.4 хувь болж 7.5 пунктээр өссөн нь эерэг үзүүлэлт гарчээ. Энэ үзүүлэлт нь 2012 онд 42 хувь, 2013 онд 45 хувь, 2014 онд мөн 45.0 хувь, 2015 онд 50.2 болж өссөөр байгаа нь сайн үзүүлэлт байна. Хонин сүргийн тооны өсөлт 2011 оноос хойш ямаан сүргийн тооны өсөлтөөс байнга дээгүүр байгаа ба 2015 оны байдлаар хонин сүргийн тоо ямаан сүргийн тооноос 53.5 мянгаар, 2016 онд 157.9 мянгаар, 2017 онд 274.1 мянгаар, 2018 онд 342.3 мянгаар илүү байна.

Зураг 5.



2018 онд тэмээн сүргийн нийт сүрэгт эзлэх хувь 0.1 пункт, хонин сүргийн нийт сүрэгт эзлэх хувь 1.0 пунктээр тус тус өсч, адуун сүргийн эзлэх хувь 0.4

пункт, үхэр сүргийн нийт сүрэгт эзлэх хувь 0.2 пункт, ямаан сүргийн эзлэх хувь 0.5 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт 8.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд, мян.толгой

	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
							хувь	зөрүү
Бойжуулсан төл	1137.2	1327.8	1440.6	1678.5	1890.5	1338.7	70.8	-551.8
Том малын зүй								
бусын хорогдол	19.7	8.9	64.6	37.8	29.3	352.3	1202.4	323
Хээлтэгч малын тоо	1387.8	1630.0	1814.7	2092.9	2285.5	2387.5	104.5	102
Хээл хаясан								
хээлтэгч	16.6	6.5	26.1	33.7	24.9	152.9	614.1	128
Сувайрсан хээлтэгч	52.3	25.5	86.0	102.6	145.3	451.3	310.6	306

Малын тоо өссөн 4 сумын хувьд хамгийн өндөр өсөлттэй нь Богд сум, хамгийн бага өсөлттэй нь Төгрөг сум байна. Малын тоо буурсан 15 сумын хувьд хамгийн өндөр бууралттай нь Бүрд сум, хамгийн бага бууралттай нь Гучин-Ус сум байна.

Хүснэгт 9.

2001 оноос хойшхи жилүүдийн малын тооны өсөлт, бууралт

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Өссөн жилийн тоо	15	13	14	15	15	15
Буурсан жилийн тоо	3	5	4	3	3	3
2001 оноос өссөн хэмжээ, мян.тол	3592.2	16.8	182.6	173.0	1677.0	1542.8
2001 оноос буурсан хэмжээ, мян.тол	-	-	-	-	-	-

2001 оноос хойшхи 18 жилийн 15 жилд нь малын тоо өсч, 3 жилд нь буурчээ. Энэ хугацаанд малын тоо 2009 онд хамгийн өндөр буюу 3620.2 мянгад хүрч байсан ба 2015 онд энэ үзүүлэлт дээшилж 4511.0 мянга, 2016 онд 5208.6, 2017 онд 5743.5 мянгад хүрээд байсан бол 2018 онд 5461.3 мянга болж буурлаа.

2018 оны байдлаар нийт мал сүргийн 88.8 хувийг бог мал, 11.2 хувийг бод мал эзэлж байна.

Хүснэгт10.


Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	100	100	100	100	100	100
Тэмээ	0.6	0.6	0.5	0.5	0.5	0.6
Адуу	5.7	5.9	6.0	6.2	6.3	5.9
Үхэр	3.8	4.2	4.5	4.8	5.2	5.0
Хонь	44.1	44.2	44.3	44.8	46.4	47.7
Ямаа	45.7	45.2	44.7	43.6	41.6	41.1

Бог малын дотор хонь 75 хувь, ямаа 25.0 хувь байсан уламжлалт харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээгээр алдагдсаар байгаа буюу жил ирэх тусам ямааны эзлэх хувь нэмэгдсээр байсан энэ харьцаа 2009 онд бага зэрэг буюу 1.4 хувиар буурсан үзүүлэлт гарч байсан. 2010 оны зудтай жилд ч өссөн үзүүлэлт гарсаар байсан байна. Нийт сүрэгт ямаан сүргийн эзлэх хувь 2008 оны эцэст 45.1 хувь байсан бол 2009 онд 43.8 хувь болж 1.3 пунктээр буурч, 2010 онд 45.2 хувь болж 1.4 пунктээр, 2011 онд 46.4 хувь болж 1.2 пунктээр өссөн харин 2012 онд 0.7 пунктээр буурсан, 2013 онд мөн 0.5 пунктээр, 2014 онд мөн 0.5 пунктээр буурч байсан ба 2015 онд бог малд хонин сүргийн эзлэх хувь 50.7 хувьд хүрсэн болсон байна. 2016 оны хувьд энэ үзүүлэлт нь 51.7 хувь болж, 2017 онд 52.7, 2018 онд 53.5 хувьд хүрчээ.

Сумдаар авч үзэхэд бог малын 33.5-73.9 хүртэлх хувийг ямаан сүрэг эзэлж байна. Хамгийн өндөр нь Богд суманд байгаа ба нийт бог малын 73.9 хувийг ямаан сүрэг эзэлж байгаа бол хамгийн бага нь Бүрд суманд нийт бог малын 33.5 хувийг ямаан сүрэг эзэлж байна. Ямаан сүргийн тоо толгойн өсөлт өндөр байх нь байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд ямар нөлөөтэйг тогтоож, сүргийн бүтцийн зохистой харьцааг тодорхойлж, энэ талаар мэргэжлийн байгууллагаас асуудал боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Зураг 6.




2018 онд Өвөрхангай аймагт нийт мал болон тэмээ, ямаан сүргийн тоогоор Богд сум, адуун сүргийн тоогоор Хужирт сум, үхэр сүргийн тоогоор Уянга сум, хонин сүргийн тоогоор Баянгол сум тус тус тэргүүлж байна.

Аймгийн хэмжээнд Богд сум 473.9 мянган толгой малаар тэргүүлж, Баянгол сум 420.1 мянган толгойгоор удаалж, Баян-Өндөр сум 377.7 мянган толгой малаар гуравдугаарт, Уянга сум 331.8 мянган толгой малаар дөрөвдүгээрт, Бүрд сум 311.9 мянган толгой малаар тавдугаарт орж байна. Таван төрлийн мал тус бүрийн дүнгээр 10.6 мянган толгой тэмээгээр Богд, 30.1 мянган толгой адуугаар Бат-Өлзий, 56.2 мянган толгой үхрээр Уянга, 234.6 мянган толгой хониор Баянгол, 326.2 мянган толгой ямаагаар Богд сум тус тус тэргүүлж байна.

Зураг 7.

Малын тоогоор тэргүүлсэн сумдууд



Хувийн /амины/ малын тоо. 2018 онд хувийн малын тоо (Аж ахуйн нэгж байгууллагын малыг хасаад) 5456.6 мянган толгой мал тоологдож, нийт малын 99.9 хувийг эзэлж байна. (Хавсралт 9.10)

Хувийн малын тоо 2017 оныхоос 281.0 мянгаар буюу 4.9 хувиар буурсан байна.

Хүснэгт11.

Хувийн малтай өрх, малын тоо

Он	Малтай өрхийн тоо, мян.өрх	Бүгд	Үүнээс:					мян.тол
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
2001	21.8	1854.2	14.7	140.5	99	900.3	699.7	
2002	20.6	1655.8	13.3	114.8	75.2	799	653.5	
2003	20.1	1910.8	13.9	123.6	82.9	876.5	813.9	
2004	19.9	2148.4	13.8	132.8	91.1	966.6	944.1	
2005	19.7	2294.3	13.1	136.4	99.6	1054.8	990.4	
2006	19.3	2616.2	13	151	111	1208.7	1132.5	
2007	20.0	3182.7	13.5	174.7	133.3	1457.1	1404.1	
2008	20.1	3443.1	14.1	172.8	134.7	1564.7	1556.8	
2009	19.9	3610.9	15.1	183.3	140.9	1684.5	1587.1	
2010	18.0	2008.4	14.7	113.7	76.2	895.0	908.8	
2011	17.2	2423.4	15.8	141.1	90.5	1 050.1	1 125.8	
2012	17.3	2967.9	18.1	170.5	113.9	1308.8	1356.5	
2013	17.6	3482.6	19.7	205.8	144.8	1538.6	1573.6	
2014	17.9	4102.6	21.9	246.6	182.7	1816.0	1835.4	
2015	18.0	4506.3	23.1	280.1	217.4	2018.4	1967.3	
2016	18.5	5203.3	26.2	323.3	259.7	2374.7	2219.4	
2017	18.9	5737.6	28.7	363.9	297.9	2659.0	2388.0	
2018	19.2	5456.6	31.4	323.5	271.8	2584.9	2245.0	

2018 оны байдлаар иргэдийн хувийн аж ахуйн нийт малын 41.1 хувийг ямаа, 47.4 хувийг хонь, 5.9 хувийг адуу, 5.0 хувийг үхэр, 0.6 хувийг тэмээ эзэлж байна.

2018 оны эцэст байгаа иргэдийн хувийн малын бүлэглэлтээс авч үзвэл 2017 оныхоос 100 хүртлэх малтай өрхийн тоо 357-оор, 101-200 толгой малтай өрхийн тоо 149-өөр, 201-500 толгой малтай өрхийн тоо 24-өөр тус тус буурч бусад бүлгийн буюу 201-с дээш толгой малтай өрхийн тоо бүх бүлэгт өссөн дүн гарчээ.

Нийт малтай өрхийн 2.0 хувь буюу 393 нь 10 хүртэл малтай, 5.8 хувь буюу 1122 өрх 11-30 хүртэл малтай, 6.8 хувь буюу 1309 өрх 31-50 хүртэл малтай, 13.0 хувь буюу 2490 өрх 51-100 хүртэл малтай, 23.0 хувь буюу 4422 өрх 101-200 малтай, 33.8 хувь буюу 6499 өрх 201-500 малтай, 11.2 хувь буюу 2152 өрх 501-999 малтай, 3.6 хувь буюу 700 өрх 1000-1499 малтай, 0.4 хувь буюу 86 өрх 1500-2000 малтай, 0.2 хувь буюу 36 өрх 2001-ээс дээш малтай байна. Малтай өрхийн бүлэглэлт тус бүрийн нийт малтай өрхөд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад 10 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 0.3 пунктээр, 11-30 хүртэл малтай өрхийнх 0.5 пунктээр, 31-50 хүртэл малтай өрхийнх 0.4 пунктээр, 51-100 хүртэл малтай өрхийнх 0.2 пунктээр, 101-200 хүртэл малтай өрхийнх 0.5 пунктээр тус тус нэмэгдсэн бол 201-500 хүртэл малтай өрхийнх 0.4 пунктээр, 501-999 хүртэл малтай өрхийнх 1.0 пунктээр, 1000-1499 хүртэл малтай өрхийнх 0.4 пунктээр, 1500-2000 малтай өрхийнх 0.2 пунктээр, 2001-аас дээш малтай өрхийнх 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Хүснэгт12.

Малтай өрхийн малын бүлэглэлт

	Малтай өрхийн тоо			Малтай өрхөд ногдох мал			Малын тоо, мян.тол		
	2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018
Бүгд	18520	18956	19209	281	303	284	5203.3	5737.6	5456.5
100 хүртэлх малтай	5291	4957	5314	50	52	50	266	258.7	266.9
101-200 малтай	4311	4273	4422	149	149	148	642	636.7	655.8
201-500 малтай	6107	6475	6499	316	320	318	1929	2070.3	2069.1
501-999 малтай	2027	2310	2152	667	673	667	1352.7	1553.9	1436.4
1000-1499 малтай	641	762	700	1159	1155	1141	742.7	879.9	798.6
1500-2000 малтай	101	122	86	1687	1657	1665	170.4	202.1	143.2
2001 дээш малтай	42	57	36	2393	2386	2403	100.5	136	86.5

1000 ба түүнээс дээш малтай 822 өрх байгаа нь өмнөх оныхоос 12.6 хувь буюу 119 өрхөөр буурсан байна. Баянгол сум 105 мянгат малчны тоогоор

тэргүүлж, Баян-Өндөр сум 91 мянгат малчинтайгаар хоёрдугаарт, Бүрд сум 80 мянгат малчинтайгаар гуравдугаарт орж байна. Аймгийн хэмжээнд 2001-ээс дээш мал тоолуулсан 36 өрх байгаагийн 50 хувь нь Бүрд, Баянгол, Гучин-Ус суманд байна.

Малтай 1 өрхөд дунджаар тэмээ 2, адуу 17, үхэр 14, хонь 135, ямаа 117 ноогдож байна.

Малтай нэг өрхөд ногдох малын тоо (толгойгоор) аймгийн 19 сумын 4 суманд урд оноос өссөн, бусад суманд буурсан үзүүлэлт гарсан ба 2018 онд Гучин-Ус сум малтай нэг өрхөд ноогдох малын тоогоор тэргүүлж байна. Гучин-Ус сумын малтай нэг өрхөд 456 толгой мал ноогдож байна. Энэ үзүүлэлт нь өмнөх онд Бүрд суманд хамгийн өндөр буюу 500 толгой байсан байна.

Хүснэгт 13.

Малтай 1 өрхөд ногдох малын тоо, төрлөөр

	2016	2017	2018					
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
ДҮН	281	238	284	2	17	14	135	117
10 хүртэл малтай	7	8	7	-	1	3	1	2
11-30 малтай	22	29	22	-	1	3	7	10
31-50 малтай	41	46	41	-	2	5	16	19
51-100 малтай	74	81	75	-	4	7	30	33
101-200 малтай	149	157	148	-	10	11	63	64
201-500 малтай	316	264	318	1	19	16	142	139
501-999 малтай	667	460	667	4	36	25	328	274
1000-1499 малтай	1159	776	60	61	62	63	64	65
1500-2000 малтай	1687	936	1665	21	104	54	933	553
2001 дээш малтай	2393	1327	2403	43	196	73	1383	709

Хээлтэгч мал. 2018 оны эцэст 2387.5 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь 2017 оныхоос 102.1 мянган толгойгоор өссөн дотор ингэ 0.6 мянгаар, гүү 1.1 мянга, эм хонь 49.8 мянга, эм ямаа 51.5 мянган толгойгоор тус тус өсч, үнээ 1.2 мянгаар буурсан байна.

Хүснэгт 14.

Хээлтэгч малын тоо

	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
							хувь	зөрүү
Бүгд	1387.8	1630.0	1814.7	2092.9	2285.5	2387.5	104.5	102
Ингэ	7.6	7.8	8.4	9.3	10.3	10.9	105.8	0.6
Гүү	59.8	71.3	82.2	96.7	109.4	110.5	101.0	1.1
Үнээ	51.8	64.5	75.9	91.0	104.3	103.1	98.8	-1.2
Эм хонь	641.9	758.8	849.5	997.8	1105.2	1155.0	104.5	49.8

Эм ямаа	627.4	727.6	798.8	898.1	956.4	1007.9	105.4	51.5
---------	-------	-------	-------	-------	-------	--------	-------	------

Хээлтэгч мал нийт малын 43.7 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 34.8 хувь, адуун сүргийн 34.1 хувь, үхэр сүргийн 37.8 хувь, хонин сүргийн 44.6 хувь, ямаан сүргийн 44.9 хувийг тус тус эзэлж байна.

Зураг



Нийт 2387.5 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 43.7 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 4.5 хувиар буюу 102.1 мянган толгойгоор өсч, нийт малд эзлэх хувийн жин урд оноос 3.9 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 15.

Төл бойжилт, мян.тол

	Бүгд			Үүнээс:				
	2016	2017	2018	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	1710.4	1956.6	1657.8	5.2	58.0	75.8	865.2	653.5
Бойжсон төл	1678.5	1890.5	1338.7	5.1	46.9	64.9	740.8	481.0
Бойжилтийн хувь	98.1	96.6	80.8	98.1	80.9	85.6	85.6	73.6

Оны эхний төллөх эх малын 72.5 хувь буюу 1657.8 мянган эх мал төллөж, гарсан төлийн 80.8 хувь буюу 1338.7 мянган толгой төл бойжуулсан байна.

Бойжсон төлийн тоо 2017 оныхоос 551.8 мянган толгойгоор буюу 29.2 хувиар өссөн байна. Гарсан ботгоны 98.1 хувь, унаганы 80.9 хувь, тугалны 85.6 хувь, хурганы 85.6 хувь, ишигний 73.6 хувийг бойжуулсан байна.

Зураг 9.

Айвэрлалын өсөлт



Бойжуулсан төл 2017 оныхоос тэмээнээс бусад төрөл дээр буурсан үзүүлэлт гарсан байна.


Хүснэгт 16.

Бойжуулсан төл

	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	1137.2	1327.8	1440.6	1678.5	1890.5	1338.7
Тэмээ	2.9	3.6	3.5	4.4	4.9	5.1
Адуу	45.1	53.7	63.7	73.3	89.0	46.9
Үхэр	39.1	48.9	59.6	69.5	84.8	64.9
Хонь	528.9	625.9	699.1	807.9	925.2	740.8
Ямаа	521.0	595.6	614.7	723.4	786.6	481.0

Зураг 10.

100 үгүйн айвэрлалын өсөлт



Хүснэгт 17.

100 эхээс бойжуулсан төл

	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	95.5	95.7	95.7	92.5	90.3	56.1
Тэмээ	46.6	48.4	50.5	52.5	53.0	46.5
Адуу	91.4	89.9	89.9	89.1	92.0	42.5
Үхэр	93.3	94.7	94.7	91.6	93.2	62.9
Хонь	96.5	97.5	97.5	95.1	92.7	64.1
Ямаа	96.3	95.6	94.9	94.9	90.6	47.7

Том малын зүй бус хорогдол. 2018 онд оны эхний малын 6.5 хувьтай тэнцэх 352.3 мянган толгой мал хорогдсон байна. Мал өвөлжилт, хаваржилт 2009-2010 онд өмнөх жилүүдээс хүндэрч, 1664.3 мянган толгой том мал зүй бусаар хорогдоод байсан бол 2011 онд эрс буурч, 2012 онд 2011 оноос 3 дахин буурчээ. 2013 онд харин 2012 оноос 1.4 дахин буюу 11655 толгойгоор өссөн байна. 2014 онд өмнөх оноос 1 дахин буурч 8.9 мянган толгой мал хорогдсон байна. 2015 онд 64.6 мянга, 2016 онд 37.8 мянга, 2017 онд 29.3 мянга, 2018 онд 352.3 мянган толгой мал хорогджээ. 2018 онд нийт хорогдсон малын 42.4 хувийг ямаа, 39.8 хувийг хонь, 2.3 хувийг адуу, 8.4 хувийг үхэр, 0.1 хувийг тэмээний хорогдол эзэлж байна.

Хүснэгт 18.

Том малын зүй бусын хорогдол

	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	19.7	8.9	64.6	37.8	29.3	352.3
Тэмээ	0.02	0.03	0.2	0.02	0.05	0.2
Адуу	0.8	0.4	2.8	2.0	0.8	32.9
Үхэр	0.8	0.3	1.5	1.6	0.9	29.5
Хонь	8.2	3.4	25.5	15.3	10.9	140.3
Ямаа	9.9	4.6	34.6	18.9	16.6	149.4

Том малын хорогдол Бүрд суманд хамгийн өндөр буюу 58.0 мянган толгой мал хорогдсон байна. Баян-Өндөр, Баянгол, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Богд, Төгрөг сумдуудад 2.1-8.9 мянган толгой мал хорогдсон ба бусад 13 сумдад 11.9-58.0 мянган толгой мал хорогдсон байна.

Зураг 11.



Оны эхний малд зүй бус хорогдлын эзлэх хувь

	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	0.6	0.2	1.4	0.8	0.6	6.5
Тэмээ	0.1	0.1	0.8	0.1	0.2	0.6
Адуу	0.4	0.2	1.0	0.7	0.3	10.2
Үхэр	0.6	0.2	0.7	0.7	0.3	10.8
Хонь	0.5	0.2	1.3	0.8	0.5	5.4
Ямаа	0.6	0.3	1.8	1.0	0.7	6.7

2018 онд нийт хорогдлын 31.3 хувь буюу 110.1 мянган толгой мал гэнэтийн аюулаар, 4.1 хувь буюу 14.5 мянган толгой мал өвчнөөр, 64.6 хувь буюу 227.7 мянган толгой мал бусад шалтгаанаар хорогджээ.

Хүснэгт20.

Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	3660	820	7796	4974	12866	110085
Тэмээ	-	-	14	7	15	75
Адуу	16	27	510	292	240	10519
Үхэр	29	22	201	177	365	6605
Хонь	1614	410	3980	2057	5108	49478
Ямаа	2001	361	3091	2441	7138	43408

Малын хээл хаялт, сувайралт. 2018 онд оны эхний хээлтэгч малын 6.7 хувьтай тэнцэх 152.9 мянган мал хээл хаяж, 19.7 хувьтай тэнцэх 451.3 мянган мал сувайрсан байна. Хээл хаясан хээлтэгч малын тоо 2017 онхоос 128.0 мянган толгойгоор, сувайрсан хээлтэгч малын тоо 306.8 мянган толгойгоор өсчээ.

Хүснэгт21.

Хээл хаясан, сувайрсан эх малын тоо

	Сувайрсан						Хээл хаясан						мян.тол
	2013	2014	2015	2016	2017	2018	2013	2014	2015	2016	2017	2018	
Бүгд	52.3	55.8	86.0	102.6	144.5	451.3	16.6	11.8	26.1	33.7	24.9	152.9	
Ингэ	0.06	0.1	0.08	0.05	0.08	0.2	0.003	0.005	0.005	0.005	0.04	0.006	
Гүү	4.2	4.9	6	9.1	9.0	32.6	0.7	0.6	0.6	1.5	0.9	14.2	
Үнээ	3.2	3.8	4	6.6	7.5	22.7	0.7	0.5	1.2	1.0	0.7	4.5	
Эм хонь	22.5	21.5	33.3	38.9	63.1	196.7	5.4	4.2	6.7	8.0	6.9	36.5	
Эм ямаа	22.2	25.5	42.5	47.9	64.7	198.9	9.8	6.5	17.6	23.2	16.4	97.8	

Хүснэгт22.

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь


	Хээл хаясан						Сувайрсан					
	2013	2014	2015	2016	2017	2018	2013	2014	2015	2016	2017	2018

Бүгд	1.4	3.4	1.6	1.9	1.1	6.4	4.4	0.7	5.3	5.7	6.3	18.9
Ингэ	0.05	1.7	0.1	0.1	0.4	0.1	0.9	0.1	1.1	0.5	0.7	2.1
Гүү	1.4	7.0	0.9	1.9	0.9	12.8	8.5	0.8	8.4	11.1	8.3	29.5
Үнээ	1.6	5.9	1.9	1.3	0.6	4.4	7.7	0.8	6.3	8.7	7.2	22.1
Эм хонь	1.0	2.8	0.9	0.9	0.6	3.2	4.1	0.6	4.4	4.6	5.7	17.0
Эм ямаа	1.8	3.5	2.4	2.9	1.7	9.7	4.1	0.9	5.8	6	6.8	19.7

Аймгийн хэмжээнд төл өгөөгүй хээлтэгч малын тоо 2018 онд өмнөх оноос 434.8 мянгаар буюу 3.6 дахин өссөн байна.

Зураг 12.

ᠮᠠᠯᠠᠨ ᠬᠡᠭᠡᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠡᠭᠡᠨ



Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. 2018 онд 37.6 мянган хээлтүүлэгч мал тоологдож, 2017 оныхоос 3.6 мянган толгойгоор буюу 8.8 хувиар буурсан байна. 2017 оныхоос буур 20-иор нэмэгдэж, бух 684, азарга 125, хуц 1369, ухна 1482 толгойгоор тус тус буурчээ.

Хүснэгт 23.

Хээлтүүлэгч малын тоо

МЯН.ТОЛ

	Хээлтүүлэгч мал						Үүнээс: шинээр тавьсан					
	2013	2014	2015	2016	2017	2018	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	29286	33125	35146	38988	41281	37641	91	37	39	24	32	22
Буур	238	239	251	290	301	321	-	-	1	1	-	3
Азарга	7272	8340	9077	10346	11447	11322	38	20	24	24	22	8
Бух	2157	2612	2896	3517	3612	2928	16	6	4	4	8	2
Хуц	9968	11178	11936	13259	14073	12704	28	6	7	7	1	3
Ухна	9651	10756	10986	11579	11848	10366	9	5	3	3	1	6

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 50-67 хээлтэгч ногдох ёстой ба 2018 онд аймгийн дунджаар 91 эм хонь, 97 эм ямаа ногдож байгаа нь

үржлийн нормоос нэлээд дээгүүр, бод малын хувьд ингэ 34 байгаа нь үржлийн нормоос 14-өөр дээгүүр, үнээ 35 байгаа нь үржлийн нормоос 5-аар дээгүүр, гүү үржлийн нормын түвшинд байна.

Хүснэгт 24.

Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо

		МЯН.ТОЛ					
	Үржлийн норм	2013	2014	2015	2016	2017	2018
Ингэ	15-20	30	33	33	32	34	34
Гүү	10-15	8	9	10	9	10	10
Үнээ	25-30	24	25	26	26	29	35
Эм хонь	50-67	64	68	71	75	78	91
Эм ямаа	50-67	65	68	73	78	81	97

Малын хэрэглээний зарлага. 2018 онд оны эхний нийт малын 22.1 хувьтай тэнцэх 1368.6 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2017 оныхоос 57.6 мянган толгойгоор буюу 4.3 хувиар буурсан байна. Хэрэглээнд зарцуулсан малын тоо тэмээ, ямааны төрөл дээр буурч, бусад төрөл дээр өссөн үзүүлэлт гарсан байна.

Малтай нэг өрх дунджаар 66 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан байна. Үүнийг аймгийн хэмжээний нийт өрхөөр тооцвол нэг өрхөд дунджаар 37 толгой мал ногдож байна.


Хүснэгт 25.

Малын хэрэглээний зарлага

		МЯН.ТОЛ					
		2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд		602.2	693.4	976.5	943.1	1326.2	1268.6
Тэмээ		1.3	1.4	2.2	1.2	2.4	2.2
Адуу		8.9	12.3	27.6	28.1	47.5	54.5
